

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил .....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	7
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал .....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	14
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	19
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	20

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ШУА	Шинжлэх ухааны академи



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ТҮҮХ, УГСААТНЫ ЗҮЙН  
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ  
С.ЧУЛУУН ТАНАА

2020.03.06 № 06/736  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал С.Чулуун Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах, эд хөрөнгийн бүртгэлийг сайжруулах, холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 2 дугаар сарын 08-наас 2020 оны 02 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Ниямазон аудит” ХХК-ны аудитор Ж.Ядмаа, аудиторын туслах Ж.Ариунаа хариуцаж хэрэгжүүлэв.

Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Ниямазон аудит ХХК-д 2020 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн 1/35а дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Түүх, угсаатны зүйн хүрээлэн нь зорилгоо “Салбарын шинжлэх ухааныг хөгжүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэлхийн жишгээр явуулж, инновацийг бий болгож үр дүнг практикт нэвтрүүлэх, шинжлэх ухааны орчин үеийн ололт амжилтыг түгээн дэлгэрүүлэх” гэж тодорхойлжээ.

Шинжлэх ухааны академийн Ерөнхийлөгчийн 2019 оны А/152 дугаар тушаалын 6 дугаар хавсралтаар Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн дүрмийг баталж үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- холбогдох салбарын онолын суурь судалгаа явуулж, захиалгат болон хамтарсан төслүүдийг гүйцэтгэх замаар судалгаа-боловсруулалтын ажлын үр дүнг шинэлэх ухаанд болон практикт нэвтрүүлэх;
- бусад эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуульд хийгдэж байгаа судалгаа шинжилгээний болон сургалтын ажилд оролцох, эрдэмтдийн залуу халааг бэлтгэх;
- олон улс, бүс нутаг, гадаад орнуудын болон дотоодын аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран судалгаа шинжилгээний ажил хийх, түүний үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, худалдах, патентлах, олон улсын байгууллага болон гадаад орнуудаас эрдэмтэн мэргэжилтэн урьж хамтарч ажиллах, өөрийн эрдэмтэн мэргэжилтнийг гадаад орнуудад явуулах асуудлыг шийдвэрлэх;
- Олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний хурал, симпозиум, сургалт, семинар, хээрийн экскурс зохион байгуулах, ном бүтээл хэвлэх;
- зохих зөвшөөрлийн дагуу дангаараа болон бусад байгууллагатай хамтран туршилт-үйлдвэрлэлийн түшиц цех, нэгж байгуулах, шинжилгээ судалгааны ажлын онол, арга зүйн түвшинг дээшлүүлж, үйлдвэрлэл практикт нэвтрүүлэх ажлын зохицуулалт хийх;
- эрдэм шинжилгээний ажлын үр дүнд үндэслэн ШУА-ийн Их, Бага чуулганаар уламжлан төр засгийн байгууллагад санал, зөвлөмж оруулах, үйл ажиллагааныхаа тайланг тогтоосон хугацаанд ШУА-ийн Тэргүүлэгчдийн газарт тайлагнах гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд томоохон өөрчлөлт ороогүй байна.

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус хүрээлэнгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Түүх, угсаатны зүйн хүрээлэн нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Acolous программ хангамж ашигладаг байна.

Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

#### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй

нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 11 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 456,457.1 мянган төгрөгөөс тооцон 9,129.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 21,800.8 мянган төгрөгөөр тооцсон нь тус хүрээлэн 2019 оны 8 дугаар сард өөрчлөгдөн зохион байгуулагдсантай учраас материаллаг байдлын суурийг нийт хөрөнгийн дүнгээс тооцоолсонтой холбоотой байна.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Засгийн газрын 2019 оны 328 дугаар тогтоолоор Түүх, угсаатны зүйн хүрээлэнг байгуулж шинэчлэн зохион байгуулж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 430 дугаар тогтоолоор Түүх, археологийн хүрээлэнгээс нийт 2,440,843.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	0.0	64,790.1	64,790.1
Бараа материал	0.0	96,810.6	96,810.6
Үндсэн хөрөнгө	0.0	2,059,192.8	2,059,192.8
Хуримтлагдсан элэгдэл	0.0	(40,715.7)	(40,715.7)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>0.0</b>	<b>2,180,077.8</b>	<b>2,180,077.8</b>
Өмч	0.0	2,058,673.8	2,058,673.8
Хуримтлагдсан үр дүн	0.0	121,404.0	121,404.0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>0.0</b>	<b>2,180,077.8</b>	<b>2,180,077.8</b>

2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүнд авлага 2.0 хувь, бараа материал 4.0 хувь, үндсэн хөрөнгө 94.0 хувь эзэлж байна.

Авлагын данс 64,790.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь татаас, санхүүжилтийн 44,703.6 мянга, Нийгмийн даатгалын шимтгэлийн 1,354.6 мянга, ном хэвлэлийн 12,301.0 мянга, шатахууны 6,430.8 мянган төгрөгийн авлагаас бүрдэж байна.

Бараа материалын дансанд үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 104,425.0 мянга, худалдан авсан 41,683.7 мянга, нийт 146,108.7 мянган төгрөгийн орлогын гүйлгээ хийгдэж, 42,867.3 мянган төгрөгийн бараа материалыг зарлагдсан байна.

Үндсэн хөрөнгө дансанд балансад балансад шилжүүлэн авсан 2,058,673.8 мянга, худалдан авсан 519.0 мянга, нийт 2,059,192.8 мянган төгрөгийн орлого орж, хөрөнгө хасагдаагүй байна.

## **2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Түүх, угсаатны зүйн хүрээлэн тайлант онд улсын төсвөөс 306,300.6 мянган төгрөгөөр санхүүжилт авч, үйл ажиллагаанаас 5,311.9 мянган төгрөг, нийт 311,612.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал зардалд 311,380.5 мянган төгрөг зарцуулж, 232.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### **Нэмэлт төсөв**

Дээд шатны төсвийн захирагчаас 126,122.9 мянган төгрөг, давсан орлого 46,991.9 мянган төгрөгийн нийт 173,114.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 128,211.4 мянган төгрөгийг зарцуулж, 44,903.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Үүнээс 44,703.6 мянган төгрөгийг татаас, санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 11 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 12 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 21,236.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 6,430.8 мянган төгрөгийн төлбөрийн алдааг залруулж, 14,805.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Аудитаар дараах 6,430.8 мянган төгрөгийн зөрчлийг залрууллаа. Үүнд:

Петростар ХХК-иас авах авлага 6,430.8 мянган төгрөгийг бараа материалын дансанд буюу шатах тослох материалаар бүртгэсэн нь УСНББОУС 12-ын 9-д “бараа материалд дараах хөрөнгө орно: а. Үйлдвэрлэлийн явцад ашиглагдах материал буюу хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа; б. Үйлчилгээ үзүүлэхэд хуваарилагдах эсвэл хэрэглэгдэх материал буюу хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа; в. Үйл ажиллагааны хэвийн үед борлуулах буюу хуваарилахаар эзэмшиж байгаа; г. Худалдан борлуулах эсвэл хуваарилах зорилгоор үйлдвэрлэлийн явцад байгаа хөрөнгө” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Бараа материалын данснаас 6,430.8 мянган төгрөгийг хасаж, авлагын дансны үлдэгдлийг нэмэгдүүлэн залруулав.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Хандивын хөрөнгийн зарцуулалтыг 2020 оны аудитын тайлангаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хугацаа хоцроож өссөн дүнгээр 2019 оны 12 дугаар сард байршуулсан байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй.



#### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### **3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### *1. Балансын данстай холбоотой асуудал*

##### *1.1. Илрүүлэлт:*

Нийгмийн даатгалын шимтгэлд 1,354.6 мянга, ном хэвлэлийн төлбөрт Удам соёл ХХК-д 1,460.6 мянга, Мөнхийн үсэг ХХК-д 9,689.1 мянга нийт 13,655.6 мянган төгрөг шилжүүлж авлага үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасан “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг зөрчсөн байна.

##### *1.2. Эрсдэл:*

Төсвийн тухай хууль зөрчигдөх, батлагдсан төсвийг хэтрүүлж зарцуулах;

##### *1.3. Өгсөн зөвлөмж:*

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийг хэрэгжүүлж авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах

##### *1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

#### *2. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа*

##### *2.1. Илрүүлэлт:*

Түүх, археологийн хүрээлэнгийн захирал нь Манзуширын хийдэд Археологийн хээрийн шинжилгээний ангид малтлага болон аж ахуйн ажил хийх хөдөлмөрийн гэрээг өөртэйгээ 2018 оны 10 дугаар сарын 10-нд байгуулж, 2019 оны 1 сард 1,150.0 мянган төгрөгийн цалин авсан байна. Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн ... хувийн ашиг сонирхлыг хөндсөн ... гэрээ байгуулахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна.

## 2.2. Эрсдэл:

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль зөрчигдөх;

## 2.3. Өгсөн зөвлөмж:

Гэрээ байгуулахдаа холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах, хүрээлэнгийн захирал дахин өөртэйгээ гэрээ байгуулж, цалин олгохгүй байх

## 2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

## *3. Биет хөрөнгөтэй холбоотой асуудал*

### 3.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгөө кодлоогүй, техник ашиглалтын паспорт хөтлөөгүй, ажилчин, албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлд тооллогын комисс, ажиллагсдын гарын үсэггүй, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан маягтыг мөрдөөгүй.

### 3.2. Эрсдэл:

Байгууллагын өмч хөрөнгө шамшигдах, анхан шатны бүртгэл хөтлөөгүй байх;

### 3.3. Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн "ACOLOUS" программд бүртгэсэн кодын дагуу хөрөнгөө кодлох, кодыг наах, техник ашиглалтын паспорт хөтлөх, ажилчин албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлийг Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан маягтын дагуу хөтлөх

### 3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b><u>161,600,679.36</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>		64,790,071.73
33300	Татаас, санхүүжилтийн авлага		44,703,584.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>		20,086,487.73
3351	Байгууллагаас авах авлага		20,086,487.73
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>		96,810,607.63
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>		96,810,607.63
35410	Бичиг хэргийн материал		3,248,080.00
35420	Аж ахуйн материал		49,390,779.46
35440	Түлш, шатах тослох материал		1,889,167.36
35470	Бусад хангамжийн материал		42,282,580.81
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b><u>2,018,477,127.59</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>		2,018,477,127.59
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>		1,938,901,397.13
39201	Барилга, байгууламж, орон сууц		1,754,870,320.04
39202	Хуримтлагдсан элэгдэл		(23,398,270.92)
39203	Авто-тээврийн хэрэгсэл		17,315,748.00
39204	Хуримтлагдсан элэгдэл		(961,986.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		45,211,714.33
39206	Хуримтлагдсан элэгдэл		(7,781,397.56)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		13,466,834.21
39208	Хуримтлагдсан элэгдэл		(3,343,033.32)
39214	Бусад үндсэн хөрөнгө		52,258,787.99
39215	Хуримтлагдсан элэгдэл		(5,023,980.64)
39217	Ном		96,286,661.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>		79,575,730.46
39301	Програм хангамж		769,916.58
39302	Хуримтлагдсан элэгдэл		(206,986.12)
39303	Бусад биет бус хөрөнгө		79,012,800.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>		<b><u>2,180,077,806.95</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b><u>2,180,077,806.95</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>		2,058,673,782.15
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		2,058,673,782.15
51101	Өмч: - төрийн		2,058,673,782.15
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>		121,404,024.80
51210	Өмнөх үеийн үр дүн		(2,069,964,904.35)
51220	Тайлант үеийн үр дүн		2,191,368,929.15
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>		<b><u>2,180,077,806.95</u></b>

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>		<b>2,647,826,088.56</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>		<b>2,168,410,695.27</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>		2,168,410,695.27
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		2,168,410,695.27
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		4,936,911.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		375,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		2,163,098,784.27
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>		<b>479,415,393.29</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>		306,300,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		306,300,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		173,114,793.29
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		126,122,893.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		46,991,900.29
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>456,457,159.41</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>453,149,358.78</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		453,149,358.78
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		236,582,290.29
210101	Үндсэн цалин		159,575,234.00
210102	Нэмэгдэл		56,088,596.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт		14,750,000.00
210105	Гэрээт ажлын хөлс		6,168,460.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		41,113,280.00
210201	Тэтгэврийн даатгал		28,000,326.48
210202	Тэтгэмжийн даатгал		2,961,770.17
210203	ҮОМШӨ-ний даатгал		2,369,416.14
210204	Ажилгүйдлийн даатгал		592,354.03
210205	Эрүүл мэндийн даатгал		7,189,413.18
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>		14,842,115.13
210301	Гэрэл, цахилгаан		7,840,346.89
210302	Түлш, халаалт		4,829,879.46
210303	Цэвэр, бохир ус		2,171,888.78
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		9,367,026.24
210401	Бичиг хэрэг		3,122,955.00
210402	Тээвэр, шатахуун		3,415,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		619,859.24
210404	Ном, хэвлэл		149,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		575,000.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		1,485,112.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		11,732,970.00
210604	Урсгал засвар		11,732,970.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>58,718,279.71</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		58,442,679.71
210804	Тээврийн хэрэгслийн татвар		194,400.00
210807	Газрын төлбөр		81,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		80,793,397.41
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		40,077,742.85
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		40,715,654.56
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>3,307,800.63</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		<b>2,876,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		2,876,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>431,800.63</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		232,000.34
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		199,800.29
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>		<b><u>2,191,368,929.15</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>		<b><u>2,191,368,929.15</u></b>

#### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>		<b><u>484,727,304.29</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>		<b>5,311,911.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>		5,311,911.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>		5,311,911.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		4,936,911.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		375,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>		<b>479,415,393.29</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>		<b>306,300,600.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		306,300,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>173,114,793.29</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		126,122,893.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		46,991,900.29
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>		<b><u>484,208,304.29</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>436,196,919.66</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>436,196,919.66</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		<b>236,582,290.29</b>
210101	Үндсэн цалин		159,575,234.00
210102	Нэмэгдэл		56,088,596.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт		14,750,000.00
210105	Гэрээт ажлын хөлс		6,168,460.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		<b>41,113,280.00</b>
210201	Тэтгэврийн даатгал		28,000,326.48
210202	Тэтгэмжийн даатгал		2,961,770.17
210203	ҮОМШӨ-ний даатгал		2,369,416.14
210204	Ажилгүйдлийн даатгал		592,354.03
210205	Эрүүл мэндийн даатгал		7,189,413.18
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>		<b>14,842,115.13</b>
210301	Гэрэл, цахилгаан		7,840,346.89
210302	Түлш, халаалт		4,829,879.46
210303	Цэвэр, бохир ус		2,171,888.78
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>3,071,299.24</b>
210401	Бичиг хэрэг		1,567,340.00
210402	Тээвэр, шатахуун		160,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		619,859.24
210404	Ном, хэвлэл		149,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		575,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>16,580,000.00</b>
210604	Урсгал засвар		16,580,000.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>101,665,109.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		101,389,509.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		194,400.00
210807	Газрын төлбөр		81,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		<b>22,342,826.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		22,342,826.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>48,011,384.63</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		<b>2,876,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		2,876,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>45,135,384.63</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		232,000.34
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		44,903,384.29
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>		<b><u>519,000.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>		<b>519,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		<b>519,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>		<b>519,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		519,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>		<b><u>(519,000.00)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>		<b>0.00</b>



#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>0.00</b>		<b>0.00</b>	<b>0.00</b>
Тайлант үеийн үр дүн				0.00
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	2,058,673,782.15	<b>0.00</b>	(2,069,964,904.35)	(11,291,122.20)
Тайлант үеийн үр дүн	0.00	<b>0.00</b>	2,191,368,929.15	2,191,368,929.15
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,058,673,782.15</b>	<b>0.00</b>	<b>121,404,024.80</b>	<b>2,180,077,806.95</b>

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>314,120,200.00</b>	<b>311,380,510.66</b>	<b>2,739,689.34</b>	99.1
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	314,120,200.00	311,380,510.66	2,739,689.34	99.1
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>311,244,200.00</b>	<b>308,504,510.66</b>	<b>2,739,689.34</b>	99.1
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	218,956,000.00	214,808,496.29	4,147,503.71	98.1
Үндсэн цалин	147,112,300.00	143,969,900.00	3,142,400.00	97.9
Нэмэгдэл	57,093,700.00	56,088,596.29	1,005,103.71	98.2
Унаа хоолны хөнгөлөлт	14,750,000.00	14,750,000.00	0.00	100.0
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>38,288,000.00</b>	<b>38,288,000.00</b>	<b>0.00</b>	100.0
Тэтгэврийн даатгал	19,355,900.00	25,175,046.48	(5,819,146.48)	130.1
Тэтгэмжийн даатгал	4,733,000.00	2,961,770.17	1,771,229.8	62.6
ҮОМШӨ-ний даатгал	3,786,400.00	2,369,416.14	1,416,983.9	62.6
Ажилгүйдлийн даатгал	946,600.00	592,354.03	354,246.00	62.6
Эрүүл мэндийн даатгал	9,466,100.00	7,189,413.18	2,276,686.8	75.9
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>14,842,200.00</b>	<b>14,842,115.13</b>	<b>84.87</b>	100.0
Гэрэл, цахилгаан	10,854,600.00	7,840,346.89	3,014,253.11	72.2
Түлш, халаалт	3,230,600.00	4,829,879.46	(1,599,279.46)	149.5
Цэвэр, бохир ус	757,000.00	2,171,888.78	(1,414,888.78)	286.9
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,210,300.00</b>	<b>3,210,299.24</b>	<b>0.76</b>	100.0
Бичиг хэрэг	1,223,800.00	1,517,340.00	(293,540.00)	124.0
Тээвэр, шатахуун	80,000.00	160,000.00	(80,000.00)	200.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,412,500.00	619,859.24	792,640.76	43.9
Ном, хэвлэл	111,600.00	338,100.00	(226,500.00)	303.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	382,400.00	575,000.00	(192,600.00)	150.4
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>16,580,000.00</b>	<b>16,580,000.00</b>	<b>0.00</b>	100.0
Урсгал засвар	16,580,000.00	16,580,000.00	0.00	100.0
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,288,000.00</b>	<b>0.00</b>	<b>3,288,000.00</b>	0.0
Дотоод албан томилолт	3,288,000.00	0.00	3,288,000.00	0.0
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>16,079,700.00</b>	<b>20,775,600.00</b>	<b>(4,695,900.0)</b>	129.2
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,750,000.00	20,500,000.00	(4,750,000.0)	130.2
Тээврийн хэрэгслийн татвар	248,500.00	194,400.00	54,100.00	78.2
Газрын төлбөр	81,200.00	81,200.00	0.00	100.0
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,876,000.00</b>	<b>2,876,000.00</b>	<b>0.00</b>	100.0
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,876,000.00</b>	<b>2,876,000.00</b>	<b>0.00</b>	100.0
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,876,000.00	2,876,000.00	0.00	100.0

<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>318,870,200.00</b>	<b>311,380,510.66</b>	<b>(5,079,910.66)</b>	101.7
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>306,300,600.00</b>	<b>306,068,599.66</b>	<b>232,000.34</b>	99.9
Улсын төсвөөс санхүүжих	306,300,600.00	306,068,599.66	232,000.34	99.9
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>12,569,600.00</b>	<b>5,311,911.00</b>	<b>7,257,689.00</b>	42.3
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,711,600.00	4,936,911.00	774,689.00	86.4
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,858,000.00	375,000.00	6,483,000.00	5.5
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>54</b>	<b>54</b>		100.0
Удирдах ажилтан	1	1		100.0
Гүйцэтгэх ажилтан	39	39		100.0
Үйлчлэх ажилтан	14	14		100.0

#### 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>173,114,793.29</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		173,114,793.29
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>128,211,409.00</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		21,773,794.00
Үндсэн цалин		15,605,334.00
Гэрээт ажлын хөлс		6,168,460.00
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх</b>		<b>2,825,280.00</b>
Тэтгэврийн даатгал		2,825,280.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>50,000.00</b>
Бичиг хэрэг		50,000.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний</b>		<b>81,219,509.00</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		81,219,509.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		<b>22,342,826.00</b>
Бараа үйлчилгээний бусад зардал		22,342,826.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>44,903,384.29</b>
<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>44,903,384.29</b>
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		44,903,384.29
<b>НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>		<b>173,114,793.29</b>
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		126,122,893.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		46,991,900.00

**5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо:	Аудитын н нэр:	<i>Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	Аудитын код:
2020.02.21			САГ-2020/354/СТА-
Шалгагдсан байгууллагын нэр:	Түүх, угсаатны зүйн хүрээлэн		Мянган төгрөгөөр

Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
		Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5
Нийгмийн даатгалын шимтгэлд 1,354.6 мянган төгрөг, ном хэвлэлийн төлбөрт Удам соёл ХХК-д 1,460.6 мянган төгрөг, Мөнхийн үсэг ХХК-д 9,689.1 мянган төгрөг нийт 13,655.6 мянган төгрөг шилжүүлж, авлага үүсгэсэн тул зөвлөмж өгөх	13,655.6	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	О.Баярсайхан
Түүх, археологийн хүрээлэнгийн захирал С.Чулуун нь Манзуширын хийдэд Археологийн хээрийн шинжилгээний ангид малтлага болон аж ахуйн ажил хийх хөдөлмөрийн гэрээг өөртэйгээ 2018 оны 10 сарын 10 нд байгуулж, 2019 оны 1 сард 1,000.0 мянган төгрөгийн цалин авсан тул цаашид хуулийн дагуу гэрээ байгуулах зөвлөмж өгөх	1,150.0	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	О.Баярсайхан
Ажилчин, албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлд тооллогын комисс, ажиллагсдын гарын үсэггүй, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан маягтыг мөрдөөгүй	0.0	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	О.Баярсайхан
<b>Дүн</b>	<b>14,805.6</b>			





